



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/08


Мандалговь

“Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, Орон нутгийн өмчийн газрын нийт албан хаагчдын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 12 дүгээр сарын 22-ны өдрийн А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Хөдөлмөрийн дотоод журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА  С.ХУЛАН



482412025